



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

2024 онд бүрэн хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн нийт 18 төсөл, арга хэмжээний 77.8 хувь буюу 14 нь хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: СЭА-2025/ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Сүхбаатар сум	Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа	
	Утас: 70363040	Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
2025.04.20	Аудитын менежер	Б.Батмөнх
	Утас: 70363036	Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
	Ахлах аудитор	С.Баасансүрэн
	Утас: 70362442	Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
	Аудитор Ж.Цогт	Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёг	3
Дүрслэлийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	5
1 дүгээр бүлэг: Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй болон төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	6
1.1 Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний 95.6 хувийг “Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-тэй уялдуулж төлөвлөөгүй байна.	6
1.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	7
1.3 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан байна.	9
1.4 УТХО-аар хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний 60.8 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.	10
2 дугаар бүлэг: Ахмад настан болон тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг тусгаагүй буюу тодорхой 1 этгээдэд чиглэсэн техникийн тодорхойлолтыг боловсруулж, гүйцэтгэгчээр шалгаруулсан байна.	11
2.1 Эрх шилжүүлэх тушаал, шийдвэрийг журмаар тогтоосон хугацаанаас хойш гаргасан байгаа нь төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэх, хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна.	11
2.2 Захиалагч аймгийн Засаг даргын бус Сүхбаатар сумын Засаг даргын баталсан нэг этгээдэд чиглэсэн техникийн тодорхойлолтыг үндэслэн “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулсан байна.	13
2.3 Эрүүл ахуйн болон аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилгыг ахмад настны төв болон тусгай хэрэгцээт хүүхдийн сувиллын зорилгоор ашиглахаар худалдан авсан байна.	15
3 дугаар бүлэг: Захиалагч нь тайлант онд хэрэгжих боломжгүй хугацаанд гэрээ байгуулснаас шалтгаалан 3 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих болсон.	16
3.1 Улсын комиссын актаар хүлээж авсан 2 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны нийт 35.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байна.	16
3.2 Өмнөх оноос шилжих 5, шинээр хэрэгжих 13 зэрэг нийт 18 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авахаас 77.8 хувь буюу 14 нь бүрэн хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.	19
3.3 Бүрэн хэрэгжсэн 14 төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, хүлээн авсан байна.	20
3.4 Тайлант онд улсын комиссын актаар хүлээж авсан 14 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд нь бүртгэл, тайланд бүрэн тусгасан байна.	21
Илрүүлсэн зөрчил	22
Дүгнэлт	22
Зөвлөмж	23
Ирүүлсэн санал, тайлбар	25

Төрийн аудитын газрын тайлбар

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОУАӨ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ГБХНХ	Гэр бүл, хүүхэд нийгмийн хамгаалал
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТС	Зам тээврийн сайд
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Хүснэгтийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан төсөл, арга хэмжээ	7
Хүснэгт 2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр эхэлсэн төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлага хангасан байдал	9
Хүснэгт 3	Тендерийн баримт бичгийг боловсруулсан байдал	13
Хүснэгт 4	Тайлант онд гүйцэтгэлийн баталгаагаар баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	17

Дүрслэлийн товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан тендер шалгаруулалтын арга	13

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх, - Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх, - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан аймгийн ТЕЗ, ЗДТГ, ХААГ, ГХБХБГ, ОНӨГ зэрэг холбогдох байгууллага болон төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа, санхүүжилтийн баримт материалуудыг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 4000-4200, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аймгийн ТЕЗ, ЗДТГ, ХААГ, ГХБХБГ, ОНӨГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, худалдан авалт, санхүүжилттэй холбоотой баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглалаа.Үүнд: • Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт, • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, • Төсвийн тухай хууль, • Төрийн хэмнэлтийн тухай хууль, • Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, • Барилгын тухай хууль, • Эрчим хүчний тухай хууль, • Авто замын тухай хууль, • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, • УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, • Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, • Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, • Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлалууд”, • Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, • Сангийн сайдын 2023 оны А/261 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”, • Барилга байгууламжийн үнэ бүрдэл, төсөв зохиох норм, дүрэм, стандарт, • Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, аудитор Ж.Цогт нар 2025 оны 3 дугаар сарын 06-ны өдрөөс 4 дүгээр сарын 18-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.
Ерөнхий мэдээлэл:	Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Сэлэнгэ аймагт ЗГХЭГ болон 9 яаманд харьяалагдах нийт 103,248.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 35 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас аймгийн Засаг даргад нийт 40,968.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. Захиалагч нь Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар”-ыг үндэслэн 40,034.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын, 408.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын, 525.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг ерөнхий гэрээний аргаар сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, баталсан байна. Тайлант онд хэрэгжиж дуусгахаар гэрээ байгуулсан 18 төсөл, арга хэмжээнээс нийт 11,262.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 14 төсөл, арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

Бүлэг 1

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй болон төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн үү?

Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний 95.6 хувийг “Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-тэй уялдуулж төлөвлөөгүй байна.

1.1.1 УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” -ийг, 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-г тус тус баталсан байна.

1.1.2 2024 оны Төсвийн тухай хуулиар Сэлэнгэ аймагт ЗГХЭГ болон 9 яаманд харьяалагдах нийт 103,248.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 35 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас аймгийн Засаг даргад нийт 40,968.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 1-д харуулав.)

1.1.3 Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн дээрх 23 төсөл, арга хэмжээг “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр” -ийн **Хоёр.Хүний хөгжил:** Боловсрол, Эрүүл мэнд, биеийн тамир, спорт, **Дөрөв. Эдийн засаг:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, дэд бүтэц (Эрчим хүч, зам тээвэр, барилга, хот байгуулалт), **Тав.Засаглал, Долоо.Амар тайван, аюулгүй нийгэм** гэсэн үндсэн 4 зорилготой нийцүүлэн төлөвлөсөн байна.

1.1.4 Эрх шилжүүлсэн дээрх 23 төсөл, арга хэмжээнээс УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний 3.1.4.2: “Спорт заал барих” дэд зорилтын хүрээнд 1,482.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сургуулийн спорт заалны барилга (Сэлэнгэ, Сайхан сум, Номгон тосгон) гэсэн 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

1.1.5 “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний дэд зорилтуудтай уялдуулалгүйгээр 22 төсөл, арга хэмжээнд нийт 39,486.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д харуулав.)

1.1.6 2024 онд УТХО-аар Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэхээр баталж, эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд нь “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн үндсэн 4 зорилготой нийцсэн хэдий ч ихэнх төсөл, арга хэмжээг

“Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний дэд зорилтуудтай уялдуулалгүйгээр төлөвлөсөн байна.

1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөсөн үү?

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2.1 Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналаа хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байдаг.

1.2.2 Аймгийн Засаг дарга нь 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 01/633-01/638 дугаар албан бичгүүдээр 2024 оны УТХО-ын төлөвлөгөөнд тусгуулахаар нийт 129,627.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл, арга хэмжээний саналыг дараах сайд нар (тухайн үеийн нэршилээр) -т хүргүүлсэн байна. Үүнд:

- ЭМС-д нийт 1,165.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2,
- ЗТС-д нийт 24,662.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4,
- ХААХҮС-д нийт 5,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2,
- БШҮС-д нийт 19,122.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7,
- БХБС-д нийт 79,177.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл, арга гэх мэт.

1.2.3 Үүнээс 57,347.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 18 төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсанаас 35,955.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1. Аймгийн ТЕЗ-ийн хүргүүлсэн саналаас УТХО-ын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан төсөл, арга хэмжээ

/сая төгрөгөөр/

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Аймгийн ТЕЗ-аас санал хүргүүлсэн төсөл, арга хэмжээ		Аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналаас УТХО-ын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан		2024 онд хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Боловсрол, шинжлэх ухааны сайд	7	19,122.1	7	19,122.1	3	2,307.1
2	Барилга, хот байгуулалтын сайд	5	79,177.5	3	6,877.5	2	2,300.0
3	Зам тээврийн хөгжлийн сайд	4	24,662.6	4	24,682.6	4	24,682.6
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	2	5,500.0	2	5,500.0	2	5,500.0
5	Эрүүл мэндийн сайд	2	1,165.4	2	1,165.4	2	1,165.4
Нийт		20	129,627.6	18	57,347.6	13	35,955.1

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-аас сайд нарт хүргүүлсэн санал,
Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

1.2.4 Хэдийгээр аймгийн Засаг даргын хүргүүлсэн саналын 90.0 хувь нь УТХО-ын төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан ч Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1¹-д заасны дагуу төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлэх ажил хийгдээгүй байна.

1.2.5 Аймгийн Засаг даргаас санал хүргүүлээгүй, орон нутгийн хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлээгүй нийт 5,013.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах 10 төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр баталж, эрх шилжүүлсэн байна. Үүнд:

- ЗГХЭГ-ын даргын багцаас 2,453.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга (Сэлэнгэ, Түшиг сум)”,
- ГБХНХ-ын сайдын багцаас 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын хөгжлийн төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар сум),
- Сангийн сайдын багцаас 257.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Төмөр бетонон гүүр (Сэлэнгэ, Жавхлант сум)”, 650.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Орон сууцны инженерийн шугам сүлжээний ажлын зураг, төсөл (Сэлэнгэ, Мандал сум)”, 243.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн шинэ барилгад шаардлагатай байгаа тавилга, тоног төхөөрөмж”, тус бүр нь 100.0 сая төгрөг нийт 300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Цахим анги байгуулах (Сэлэнгэ, Жавхлант сумын сургууль, Мандал сумын 2 дугаар сургууль, Мандал сумын Түнхэл тосгоны сургууль), 66.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сэлэнгэ аймгийн Түшиг сумын 1 дүгээр цэцэрлэгийн гадна талбайн их засвар (Сэлэнгэ, Түшиг сум)”,
- БОУАӨ-ийн сайдын багцаас 42.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын их засвар (Улсын хэмжээнд)-д Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн конторын дээврийн их засвар) Сэлэнгэ, Сүхбаатар) гэх мэт.

1.2.6 Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлж, эрэмбэлэх ажил хийгдээгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ыг бүхэлд нь зөрчсөн байна.

1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсөв, урсгал зардлын тооцоололтой, төсөвлөлтийн бусад шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг тусгасан уу?

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан байна.

¹ Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

1.3.1 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²-т хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахаар зохицуулагдсан байдаг.

1.3.2 Тайлант онд УТХО-аар хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 23 төсөл, арга хэмжээнээс төсөвлөлтийн шаардлага хангаагүй 6 төсөл, арга хэмжээ (зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй зөрчлийг тайлангийн 1.4-т оруулсан болно.) -г төлөвлөсөн байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр эхэлсэн төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлага хангасан байдал /сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар баталсан эсэх	Газрын зөвшөөрөл олгосон огноо	Техникийн нөхцөл олгосон огноо				Магадлалын ерөнхий дүгнэлт	
					Цахилгаан хангамж	Дулаан хангамж	Ус хангамж, ариутгах татуурга	Холбоо дохиолол	Огноо	Хянагдсан төсвийн дүн
1	Төмөр бетонон гүүр /Сэлэнгэ, Жавхлант сум/	257.1	Батлаагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй				Зураг, төсвийг магадлалаар батагаажуулаагүй	
2	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Сэлэнгэ, Түшиг сум/	2,453.9	2023.10.02	2012.04.24	2021.09.22	2024.04.30	Аваагүй	Аваагүй	Зураг, төсвийг магадлалаар батагаажуулаагүй	
3	Орон сууцны хорооллын дэд бүтцийн шугам, сүлжээ /Сэлэнгэ, Мандал сум/	500.0	2024.11.10	Шаардлагагүй	Шаардлагагүй	Аваагүй	Аваагүй	Шаардлагагүй	Зураг, төсвийг магадлалаар батагаажуулаагүй	
4	Сумын төвийн газар доогуурх дулаан, цэвэр усны төв шугам, худаг /Сэлэнгэ, Орхонтуул сум/	1,800.0	Батлаагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй	Аваагүй	Аваагүй	Шаардлагагүй	Зураг, төсвийг магадлалаар батагаажуулаагүй	
5	Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк /Сэлэнгэ/	5,000.0	Батлаагүй	Газрын зөвшөөрөлгүй	Аваагүй	Аваагүй	Аваагүй	Шаардлагагүй	Зураг, төсвийг магадлалаар батагаажуулаагүй	
6	Нэгдсэн эмнэлгийн барилга, дотор сантехникийн засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	965.4	Батлаагүй	Шаардлагагүй	Шаардлагагүй				Зураг, төсвийг магадлалаар батагаажуулаагүй	
Нийт дүн		10,976.4								

Дээрх хүснэгтээс харахад:

- Барилга байгууламж, их засварын нийт 35,652.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээнээс Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.4³, 3.5⁴ дахь заалттай нийцээгүй 8,022.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй,
- Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2⁵, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын 6.3⁶ дахь заалтуудтай нийцээгүй нийт 10,976.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6 төсөл, арга хэмжээний зураг, төсөвт магадлал хийлгэж, баталгаажуулаагүй,

² Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

³ Архитектур төлөвлөлтийн даалгаврыг аймаг, нийслэлийн ерөнхий архитектур батална.

⁴ Захиалагч барилга байгууламжийн байршлыг тогтоосон шийдвэр, батлагдсан архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэж зураг төслийн даалгавар боловсруулж батална.

⁵ Магадлалыг дараах зураг төсөлд хийнэ: 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

⁶ Барилгын тухай хуулийн 25.2, 25.3, 25.5-д заасан зураг төсөлд заавал магадлал хийнэ.

- Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29^{1.2}⁷ дахь заалттай нийцээгүй, эрх бүхий байгууллагаас цахилгаан, дулаан, ус хангамж болон холбоо дохиоллын техникийн нөхцөлийг аваагүй нийт 9,753.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ (нийт 6 төсөл арга хэмжээнээс 2-т нь техникийн нөхцөл шаардлагагүй) гэх мэт.

1.3.3 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь төсөл арга хэмжээний явц, хэрэгжилт удаашрах, улмаар төлөвлөсөн хугацаандаа ашиглалт орохгүй байх эрсдэлтэй байна.

1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?

УТХО-аар хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний 60.8 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна.

1.4.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх үйл явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4-т заасныг мөрдөхөөр зохицуулсан байна.

1.4.2 Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 23 төсөл, арга хэмжээнээс техникийн тодорхойлолт болон зураг, төсөв нь урьдчилан хийгдээгүй нийт 14 төсөл, арга хэмжээ (барилга байгууламж 4, их засвар 2, тоног төхөөрөмж худалдан авах 8) -г хэрэгжүүлэхээр 4,900.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь “Улсын болон ... хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг хориглоно.” 13.3.3: “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.” гэсэн заалттай нийцэхгүй байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т харуулав.)

1.4.3 Дээрх төсөл, арга хэмжээнүүдийн техникийн тодорхойлолт болон зураг, төсвийг нь улсын төсөв батлагдсанаас хойш батлагдсан төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх “Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийх, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 24.1.1: “батлагдсан зураг төсөлд үндэслэсэн байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

⁷ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх: 29^{1.2.1}. тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх.

1.4.4 Өөрөөр хэлбэл Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй төсөл, арга хэмжээг УТХО-ын эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгаж, баталсан байна.

Бүлэг 2

Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан уу?

Ахмад настан болон тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сувилалд тавигдах эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгаагүй бөгөөд шаардлагатай нөхцөлүүдийг сонгон шалгаруултын дараа гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна

2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, эрх шилжүүлэх, худалдан авах ажиллагааны журмыг сонгох үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан уу?

Эрх шилжүүлэх тушаал, шийдвэрийг журмаар тогтоосон хугацаанаас хойш гаргасан байгаа нь төсөл, арга хэмжээг чанаргүй гүйцэтгэх, хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

2.1.1 УТХО-ын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1⁸-т заасны дагуу холбогдох албан тушаалтанд шилжүүлэхээр зохицуулагдсан байдаг.

2.1.2 Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 409 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-аар Сэлэнгэ аймагт 2024 онд шинээр хэрэгжих 40,968.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

2.1.3 УТХО-аар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээний эрхийг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор шилжүүлэхээр зохицуулагдсан атал Сангийн сайд нь 7 төсөл, арга хэмжээний эрхийг 2024 оны 03-06 дугаар сарын хооронд нийт 4 удаагийн тушаалаар хугацаа хоцроож шилжүүлсэн байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав.) Үүнд:

- Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 47 дугаар тушаалаар 243.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний,
- 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 78 дугаар тушаалаар 650.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний,

⁸ Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна.

- 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 97 дугаар тушаалаар 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний,
- 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 104 дүгээр тушаалаар 323.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний гэх мэт.

2.1.4 Дээрхээс бусад 39,451.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг журмаар тогтоосон хугацаанд баталгаажуулан ирүүлсэн байна.

2.1.5 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 44 дүгээр 44.1 дэх “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална” гэсэн заалтын дагуу “Сэлэнгэ аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан боловч уг төлөвлөгөөнд УТХО-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг огт тусгалгүйгээр ОНХО болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг баталсан байна.

2.1.6 УТХО-аар хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргад эрх шилжсэн, шинээр эхлэх 23 төсөл, арга хэмжээнээс Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар” баталсан 02 дугаар тогтоолыг



баримтлан 525.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг ерөнхий гэрээний аргаар, 40,034.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар, 408.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын

аргаар сонгон шалгаруулахаар баталсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав.)

2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан уу?

Захиалагч аймгийн Засаг даргын бус Сүхбаатар сумын Засаг даргын баталсан техникийн тодорхойлолтыг үндэслэн “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулсан байна

2.2.1 УТХО-аар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г аймгийн Засаг даргын захирамжаар бус ХААГ-ын

даргын тушаалаар байгуулсан байгаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1⁹, 48.2.2¹⁰ дахь заалтуудыг зөрчсөн байна.

2.2.2 Сангийн сайдын 2023 оны А/258, А/259, А/260, А/261 дүгээр “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай” тушаалуудыг үндэслэн тендерийн баримт бичгийг боловсруулахаар зохицуулсан байдаг.

2.2.3 Дээрх тушаалуудаар батлагдсан жишиг баримт бичгүүдийг үндэслэн Үнэлгээний хороо нь ерөнхий гэрээний аргаар гүйцэтгэх 1-ээс бусад төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулсан байна.

Хүснэгт №3. Тендерийн баримт бичгийг боловсруулсан байдал

Тушаалын дугаар	Жишиг баримт бичгийн нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг /сая төгрөгөөр/
А/258	Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг	4	1,743.8
А/259	Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг	12	37,641.1
А/260	Үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг	1	650.0
А/261	Харьцуулалтын аргаар бараа худалдан авах, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг	5	408.8
Нийт		22	40,443.7

2.2.4 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх “Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга ... улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна” гэсэн заалтын дагуу захиалагч болох аймгийн Засаг дарга нь 8 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг баталсан байна.

2.2.5 Харин захиалагч болох аймгийн Засаг даргын бус Сүхбаатар сумын Засаг даргын баталсан бөгөөд ахмад настан, тусгай хэрэгцээт хүүхдүүдийн эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг бүрэн тусгаагүй техникийн тодорхойлолтыг үндэслэн “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилга худалдан авах /Сэлэнгэ, Сүхбаатар сум/” төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулсан байна.

2.2.6 Өөрөөр хэлбэл аймгийн төв болох Сүхбаатар сумын ахмад настууд болон тусгай хэрэгцээт хүүхдүүд үйл ажиллагаа явуулах зорилго бүхий барилгад тавигдах эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах шаардлага/дотоод засал, хийц, материал, ослын үеийн болон тусгай хэрэгцээт иргэнд зориулсан орц, гарц, шат гэх мэт /-ыг техникийн тодорхойлолтод тусгаагүй бөгөөд сонгон шалгаруулалтын дараа шаардагдах нөхцөлүүдийг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн

⁹ “Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч байна”,

¹⁰ үнэлгээний хороо байгуулах

шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана” гэсэн заалт болон 12.3¹¹-т заасныг зөрчсөн байна.



/Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилгын гадна, дотор байдал/

2.2.7 Захиалагч нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана” гэсэн заалт болон шинэчлэн батлагдсан тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн дагуу нийт 17 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн ТШЗ-37.1-т “**гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх шаардлагатай**” гэж тусгасан байна.

2.2.8 Харин дараах 5 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгааны дүнг зөрүүтэй тооцсон байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь “Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг **тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана**” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Сэлэнгэ, Түшиг сум/ төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс нь тооцож 36.8 сая төгрөгөөр илүү,
- 1,808.2 сая төгрөгийн тухайн онд санхүүжих дүнтэй 3 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах эрх олгох мэдээгдэлд гүйцэтгэлийн баталгааны 54.2 сая төгрөгийг тусгалгүйгээр зөвхөн гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ гэж зааж өгсөн,
- Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агропарк /Сэлэнгэ/ төсөл, арга хэмжээний тухайн онд санхүүжих дүн болох 3,000.0 сая төгрөгөөс тооцон 90.0 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа тооцох ёстой атал 24.7 сая төгрөгөөр буюу 65.3 сая төгрөгөөр дутуу гэх мэт.

¹¹ “Техникийн тодорхойлолтод хүний эрүүл мэнд, байгаль орчин, уур амьсгалд нөлөөлөх нөлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх шалгуур үзүүлэлтийг тусгаж болно”

2.3 Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан уу?

Эрүүл ахуйн болон аюулгүй байдлын шаардлага хангаагүй барилгыг ахмад настны төв болон тусгай хэрэгцээт хүүхдийн сувиллын зорилгоор ашиглахаар худалдан авсан байна.

2.3.1 Аймгийн Засаг даргад эрх шилжсэн 40,968.7 сая төгрөгийн өртөг бүхий 23 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх “Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ” гэсэн заалтын дагуу цахимаар зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд оруулсан байна.

2.3.2 УТХО-аар 2024 онд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын 38,249.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээнээс 11,559.1 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг 4 дүгээр сараас хойш буюу дулааны улирал эхэлснээс хойш зохион байгуулсан нь төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүсэх, улмаар ашиглалтад орохгүй удаашрах, чанарын шаардлага хангахгүй байх, он дамжин хэрэгжих зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

2.3.3 Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтын болон харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулсан нийт 22 төсөл, арга хэмжээнээс санал ирсэн 21 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн шаардлагыг хангасан гэж үзэж, гэрээ байгуулах эрх олгосон байна.

2.3.4 Харин 257.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Төмөр бетонон гүүр /Сэлэнгэ, Жавхлант сум/ төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн нийт 5 удаа зарласан боловч оролцогчийн санал ирээгүй байна.

2.3.5 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹² дахь заалтыг баримтлан 40,968.7 сая төгрөгийн 23 төсөл, арга хэмжээнээс 22 гүйцэтгэгчтэй 40,341.0 сая төгрөгийн гэрээ байгуулах эрх олгон, нийт 370.6 сая төгрөгийн тендерийн хэмнэлт үүсгэсэн байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 2-т харуулав.)

2.3.6 “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилга худалдан авах /Сэлэнгэ, Сүхбаатар сум/” төсөл, арга хэмжээнд ганц оролцогч буюу “Гурван мэргэд” ХХК-аас өөрийн эзэмшлийн Сүхбаатар сумын 2 дугаар багт байрлалтай, 1989 онд төрийн хөрөнгөөр худалдаа, үйлчилгээний зориулалтаар ашиглалтад орж, хувьчлагдсан, угсармал бетон блокон суурьтай, 64-ийн тоосгон ханатай, нам даралтын зуухтай, төвлөрсөн дулааны шугамд холбогдоогүй 2 давхар барилгыг худалдах санал ирүүлснийг гүйцэтгэгчээр шалгаруулж, аймгийн ХААГ-ын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 151 дүгээр албан бичгээр “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл”-ийг хүргүүлсэн байна.

¹² “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”

2.3.7 Бид аудитын явцад тус барилгыг тулган шалгахад цэвэр, бохир усны шугам нь салгагдсан /шугамыг холбоход шугамын хоолойд өргөтгөл хийх шаардлагатай/, плитан шалтай, дотор засал бүрэн хийгдээгүй, үйл ажиллагаа явуулах эрүүл ахуйн болон аюулгүй байдал / дотоод засал, хийц, материал, ослын үеийн болон тусгай хэрэгцээт иргэнд зориулсан орц, гарц, шат, шал гэх мэт /-ын шаардлага хангаагүй барилгыг худалдан авахаар шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлсэн байна.



/Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилгын дотор засвар хийгдсэн байдал/

2.3.8 Тендер шалгаруулалттай холбоотой захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэлээр 3 аж ахуйн нэгжээс 3 тендер шалгаруулалттай холбоотой өргөдөл, гомдлыг Сангийн яаманд хүргүүлснээс бүгд захиалагчийн шийдвэр үндэслэлтэй гэж дүгнэсэн байна.

Бүлэг 3

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан уу?

Захиалагч нь тайлант онд хэрэгжих боломжгүй хугацаанд гэрээ байгуулснаас шалтгаалан 3 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих болсон.

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль, журмын дагуу санхүүжүүлсэн үү ?

Улсын комиссын актаар хүлээж авсан 2 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны нийт 35.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байна.

3.1.1 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42.1¹³-д заасны дагуу Үнэлгээний хороо нь 100.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээ (*тайлант онд шинээр эхлэх 23 төсөл, арга хэмжээнээс 5 нь 42.8-100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2024 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.*) -ний тендерийн баримт бичгийн ТШЗ-37.1-д гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх шаардлагыг тусгасан байна.

3.1.2 Тайлант онд санхүүжих 18,062.2 сая төгрөгийн өртөг бүхий 17 төсөл, арга хэмжээ (*1 төсөл, арга хэмжээний ХАА-г 5 удаа зарлаж, нэг ч санал ирүүлээгүй тул гэрээ байгуулах эрх олгоогүй.*) -ээс 10 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч компаниудын өмнөөс Монре даатгал ХХК болон ХААН, ХАС, Голомт банк нь гүйцэтгэлийн баталгаа гаргасан байна. (*Дэлгэрэнгүйг Хавсралт 3-т харуулав.*)

3.1.3 Эдгээрээс гүйцэтгэлийн баталгааг 2024 онд санхүүжих дүнгийн 3 хувиас бага дүнгээр тогтоосон дараах 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна. Үүнд:

- 3,000.0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий “Хөдөө аж ахуйн үйлдвэржилтийн агро парк (Сэлэнгэ)” төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа нь 65.1 сая төгрөгөөр бага,
- 500.0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл (Сэлэнгэ, Сүхбаатар сум) төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа 1.5 сая төгрөгөөр бага,
- 1,227.0 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга (Сэлэнгэ, Түшиг сум) төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа 0.8 сая төгрөгөөр бага гэх мэт.

3.1.4 Харин захиалагч нь нийт 3,852.8 сая төгрөгийн тайлант онд санхүүжих дүн бүхий 7 төсөл, арга хэмжээний 115.6 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг банкны болон даатгалын байгууллагаар баталгаажуулалгүйгээр буюу гүйцэтгэлийн баталгаагүйгээр гэрээ байгуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4. Тайлант онд гүйцэтгэлийн баталгаагаар баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал /Барилга байгууламж, Их засвар, ТЭЗҮ, Тоног төхөөрөмж/	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний үнийн дүн	Тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3%-иар гүйцэтгэлийн баталгаа гаргавал зохих дүн	Гүйцэтгэлийн баталгаа гаргасан банк, даатгалын байгууллагын нэр
			Эхлэх	Дуусах						
1	Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн шинэ барилгад шаардлагатай байгаа тавилга, тоног төхөөрөмж -Багц 2	III. Тоног төхөөрөмж	2024	2024	243.8	71.5	Хос-Анар ХХК	71.5	2.1	Гүйцэтгэлийн баталгаагүй
2	Ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/	III. Тоног төхөөрөмж	2024	2024	525.0	525.0	Техно зон ХХК	497.5	15.8	Гүйцэтгэлийн баталгаагүй

¹³ Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100.0 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

3	Сургууль, цэцэрлэгийн багш нарын тоног төхөөрөмж /Сэлэнгэ/	III. Тоног төхөөрөмж	2024	2024	300.0	300.0	Шимт боловсрол ХХК	299.9	9.0	Гүйцэтгэлийн баталгаагүй
4	Хатуу хучилттай авто зам, 2.5 км /Сэлэнгэ, Баруунбүрэн сум/	I. Барилга байгууламж	2024	2025	2,781.2	1,390.6	Си Эйч Би Энд Коллеги ХХК	2,780.5	41.7	Гүйцэтгэлийн баталгаагүй
5	Сумын төвийн газар доогуурх дулаан, цэвэр усны төв шугам, худаг /Сэлэнгэ, Орхонтуул сум/	I. Барилга байгууламж	2024	2026	1,800.0	500.0	Алтай үндэс констракшн ХХК	1,785.2	15.0	Гүйцэтгэлийн баталгаагүй
6	Нэгдсэн эмнэлгийн барилга, дотор сантехникийн засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	II. Их засвар	2024	2024	965.4	965.4	Бүрэн-Одод ХХК	959.3	29.0	Гүйцэтгэлийн баталгаагүй
7	Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ/ - Багц 1	III. Тоног төхөөрөмж	2024	2024	200.0	100.3	Сүвэн-Уул ХХК	100.3	3.0	Гүйцэтгэлийн баталгаагүй
Нийт дүн					6,815.4	3,852.8		6,494.2	115.6	

3.1.5 Төсөл, арга хэмжээний эхний болон явын санхүүжилтийг хяналт хэрэгжүүлсэн эрх бүхий албан тушаалтнуудын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, ашиглагч байгууллагын тодорхойлолт, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 30.0-80.0 хувиар тооцож, гүйцэтгэгч компаниудад олгосон байна.

3.1.6 Тайлант онд өмнөх оноос шилжин хэрэгжих 5, шинээр эхлэх 20 (2024 онд 9, 2025 онд 5, 2026 онд 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан бол гүйцэтгэгч шалгараагүйгээс 1 төсөл, арга хэмжээний гэрээ байгуулаагүй) зэрэг нийт 25 төсөл, арга хэмжээний эхний болон явцын санхүүжилтийг олгосон байна.

3.1.7 Харин “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалт нь үндэслэлгүй болсон буюу эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй барилгыг худалдан авахаар шийдвэрлэснээс шалтгаалан захиалагчийн зүгээс уг барилгыг гүйцэтгэгч компани өөрийн хөрөнгөөр бүрэн засварлах шаардлагаар гэрээ байгуулж, тайлант онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн 500.0 сая төгрөгийг шилжүүлээгүй байна.

3.1.8 Улсын комиссын актаар хүлээж авсан 14 төсөл, арга хэмжээ / Өмнөх оноос шилжин хэрэгжсэн 4, 2024 онд шинээр эхэлсэн 10 төсөл, арга хэмжээ/ -ний эцсийн санхүүжилтийг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.28¹⁴, 4.8.29¹⁵-д заасны дагуу барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засварын ажлын хяналтын хуудас, гүйцэтгэлийн төсвийг үндэслэн захиалагч “Гэрээ дүгнэх маягт”-аар баталгаажуулж олгосон байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав)

3.1.9 Харин улсын комиссын актаар ашиглалтад оруулсан “Орон сууцны хорооллын дэд бүтцийн шугам, сүлжээ (Сэлэнгэ, Мандал сум)” төсөл, арга хэмжээний

¹⁴ Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ болон худалдан авах төсөл зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ тус бүрийн хяналтын хуудсыг энэ журмын хавсралтад заасан холбогдох маягтын дагуу бөглөж, баталгаажуулан ирүүлнэ.

¹⁵ Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ.

санхүүжилтийг Сангийн яамнаас оны сүүлд буюу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр шилжүүлсэн тул гүйцэтгэгч “Таван хан энерги” ХХК-д 499.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоггүй хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна.

3.1.10 Улсын комиссын актаар ашиглалтад оруулсан 14 төсөл, арга хэмжээнээс 1 (*ерөнхий гэрээгээр тоног төхөөрөмж худалдан авсан 1*)-т нь чанарын баталгааны асуудлыг тусгаагүй бол 13-т нь чанарын баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар тооцож, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулахаар гэрээнд тусгасан байна.

3.1.11 Тайлант онд хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 10 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны 390.5 сая төгрөгийг байршуулсан бол 2,207.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй “Ахмадын төвийн барилга (Сэлэнгэ, Мандал сум)” төсөл арга хэмжээний чанарын баталгааны 110.4 сая төгрөгийг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42.6¹⁶-д заасны дагуу Голомт банкны Хан-Уул бизнес төвийн 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн “Ажлын чанарын баталгаа”-аар баталгаажуулсан байна.

3.1.12 Харин дараах 2 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны нийт 35.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй байна. Үүнд:

- “Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтсийн шинэ барилгад шаардлагатай байгаа тавилга, тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээний 10.9 сая төгрөг,
- “Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар, 5 ор (Сэлэнгэ, Жавхлант сум)” төсөл, арга хэмжээний 24.1 сая төгрөг (нийт 30.4 сая төгрөг байршуулахаас 6.3 сая төгрөгийг байршуулсан).



3.1.13 2021 онд эхэлсэн 6,974.5 сая төгрөгийн анхны төсөвт өртөгтэй “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг Барилгын хөгжлийн төвийн 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 2180/2022 дугаар дүгнэлтээр 10,700.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон бөгөөд 2024 онд 1,520.7 сая төгрөгийг гүйцэтгэгч “Экстракт” ХХК-д олгосон байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга (Сэлэнгэ, Сүхбаатар сум)

3.1.14 Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 249 дүгээр тогтоолыг үндэслэн он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан болон гэрээний хугацаанд ашиглалтад хүлээлгэж өгөөгүй төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилт болох нийт 4,294.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна.

¹⁶ Гүйцэтгэгч энэ хуулийн 42.5-д заасан барьцааг энэ хуулийн 42.3-т заасан хэлбэрээр гаргаж болно.

3.1.15 Захиалагч нь өмнөх онд улсын комиссын актаар хүлээж авсан, баталгаат хугацаанд чанарын гологдол гараагүй дараах 4 төсөл, арга хэмжээний 270.9 сая төгрөгийн барьцааг чөлөөлж гүйцэтгэгч компаниудад олгосон байна. Үүнд:

- “Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээний чанарын баталгаа 136.2 сая төгрөг,
- “Нийтийн эзэмшлийн байрнуудын гадна фасад засвар (Сэлэнгэ, Сайхан сум)” төсөл, арга хэмжээний чанарын баталгаа 85.7 сая төгрөг,
- “Ерөнхий боловсролыг сургуулийн физик, хими, технологийн лабораторийн тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээний чанарын баталгаа 39.2 сая төгрөг,
- “Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт (Сэлэнгэ, Мандал сум)” төсөл, арга хэмжээний чанарын баталгаа 9.8 сая төгрөг гэх мэт.

3.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, гэрээг дүгнэсэн үү?

Өмнөх оноос шилжих 5, шинээр хэрэгжих 13 зэрэг нийт 18 төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авахаас 77.8 хувь буюу 14 нь бүрэн хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна

3.2.1 Захиалагч нь тайлант онд шинээр эхлэх 22 төсөл, арга хэмжээ (1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгараагүй) -г хэрэгжүүлэхээр нийт 40,094.6 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.2.2 Өмнөх оноос шилжин хэрэгжих 5, шинээр эхлэх 13 зэрэг нийт 18 төсөл, арга хэмжээ (барилга байгууламжийн 7, их засварын 2, тоног төхөөрөмж 8, зураг төсөв 1) -г тайлант онд хэрэгжүүлж дуусгахаар нийт 20,301.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.2.3 Тайлант онд дуусгахаар гэрээ байгуулсан 18 төсөл, арга хэмжээнээс нийт 11,262.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 14 төсөл, арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж, улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авч, “Гэрээ дүгнэх маягт”-аар баталгаажуулсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.2.4 Техникийн нөхцөлийг бүрэн аваагүй, зураг, төсвийг урьдчилан хийлгээгүй, магадлалаар баталгаажуулаагүй зэрэг төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс голлон шалтгаалж 2024 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 22.2 хувь буюу 9,068.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 4 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.2.5 Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд тайлант онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн дараах 3 төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжгүй хугацаанд буюу 11, 12 дугаар сард гэрээ байгуулж, он дамжин хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1 дэх “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална.”, 13.1.4: “төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

- 380.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Орон сууцны инженерийн шугам сүлжээний ажлын зураг, төсөл (Сэлэнгэ, Мандал сум) төсөл, арга хэмжээний “Багц 1”-ын гэрээг 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр байгуулж, хэрэгжиж дуусах хугацааг 2025 оны 02 дугаар сарын 06,
- 959.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Нэгдсэн эмнэлгийн барилга, дотор сантехникийн засвар (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээний гэрээг 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр байгуулж, хэрэгжиж дуусах хугацааг 2025 оны 03 дугаар сарын 15,
- 499.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл (Сэлэнгэ, Сүхбаатар сум) төсөл, арга хэмжээний гэрээг 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр байгуулж, хэрэгжиж дуусах хугацааг 2025 оны 04 дүгээр сарын 01 гэх мэт.

3.2.6 Тайлант онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн 6,974.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх хугацааг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.2.7 “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод зорилтот бүлгийн эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг тусгаагүйгээс захиалагчийн зүгээс уг барилгыг гүйцэтгэгч компани өөрийн хөрөнгөөр шаардлагад нийцүүлэн засварлаж 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан боловч гэрээт хугацаанд хүлээлгэн өгөх боломжгүй болж, хугацааг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хүртэл сунгасан байна.

3.2.8 255.0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Орон сууцны инженерийн шугам сүлжээний ажлын зураг, төсөл (Сэлэнгэ, Мандал сум)” төсөл, арга хэмжээний “Багц 2”-ын гэрээний хугацаа 2024 оны 12 дугаар сарын 24-нд дууссан атал захиалагч хугацааг сунгаагүй байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан уу?

Бүрэн хэрэгжсэн 14 төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, хүлээн авсан байна.

3.3.1 Тайлант онд хэрэгжүүлж дуусахаар гэрээ байгуулсан дээрх 18 төсөл, арга хэмжээнээс нийт 11,262.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээ (барилга байгууламж 6, их засвар 1, тоног төхөөрөмж 7) нь батлагдсан зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гэрээний хугацаанд бүрэн хэрэгжсэнийг улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав)

3.3.2 Аймгийн ГХБХБГ нь барилга байгууламж, их засварын өмнөх оноос шилжиж ирсэн 5, тайлант онд шинээр эхэлсэн 13 (тоног төхөөрөмж нийлүүлэх 8, зураг, төсөв боловсруулах 1, гэрээ байгуулаагүй 1 зэрэг нийт 10 төсөл, арга хэмжээ хасагдсан) зэрэг

нийт 18 төсөл, арга хэмжээнд Барилгын тухай хуулийн 37.1.4¹⁷, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.12¹⁸-т заасны дагуу захиалагчийн хяналтыг гүйцэтгэсэн байна.

3.3.3 Тус газрын холбогдох албан тушаалтнууд нь холбогдох хууль эрхийн актын дагуу хяналт хэрэгжүүлж, бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.9¹⁹, 2023 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4.1.3²⁰-т заасны дагуу төсөл арга хэмжээний явцад захиалагчийн хяналт хийж, тайлангаар баталгаажуулсан,
- Барилгын тухай хуулийн 37.1.5²¹, Засгийн газрын 2019 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.1.4²²-т заасны дагуу тайлант онд хэрэгжүүлсэн дээрх төсөл, арга хэмжээний үе шат бүрд зураг, төсөв зохиогчийн хяналтыг гэрээний үндсэн дээр зураг төсөв зохиогч компаниудаар гүйцэтгүүлж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулан, “Зураг төсөл зохиогчийн нэгдсэн дүгнэлт”-ээр баталгаажуулсан гэх мэт.

3.3.4 Харин “Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар сум)” төсөл, арга хэмжээний “Хугацаа сунгах гэрээ (2024.09.13-ны өдөр байгуулсан)-ний 7-д “Нийлүүлэгч нь энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн барилгын эвдрэл, гэмтэл, согог арилгах, өрөө тасалгааг засварлах үүрэг хүлээнэ.”, “Гэрээний тусгай нөхцөл”-ийн 3-т “Ашиглагдах бараа материалын сонголт, ... хийц эдлэлийн өнгө, загварыг захиалагч болон ашиглагчтай зөвшилцөн сонгох” гэж тусгасан боловч гүйцэтгэлийн явцад огт зөвшилцөөгүй, захиалагчийн зүгээс хяналт тавиагүй байна.

3.3.5 Тайлант онд бүрэн хэрэгжсэн техник, тоног төхөөрөмж худалдан авах нийт 1,489.4 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 7 төсөл, арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн даргаар ахлуулсан ажлын хэсгүүд нь захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, “Тоног төхөөрөмж хүлээн авсан акт”-аар баталгаажуулан хүлээж авсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав.)

3.4 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна уу?

¹⁷ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.4.барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах.

¹⁸ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

¹⁹ Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.

²⁰ Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийн санхүүжилтийн явц бүрд захиалагчийн техник, технологийн хяналтын тэмдэглэл, явцын тайлан, дүгнэлтийг тухай бүр гаргах

²¹ 37.1.Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 37.1.5.барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах.

²² Барилгын тухай хуулийн 38.1.4-т заасны дагуу зураг төсөл зохиогчтой гэрээ байгуулж, барилгын ажлын үе шатанд зохиогчийн техникийн хяналт хийлгэн дүгнэлт гаргуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах.

Тайлант онд улсын комиссын актаар хүлээж авсан 14 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагууд нь бүртгэл, тайланд бүрэн тусгасан байна.

3.4.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2²³, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.30²⁴-д заасны дагуу хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгахаар зохицуулсан байдаг.

3.4.2 Аймгийн Орон нутгийн өмчийн газраас хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл олгосныг үндэслэн тайлант онд улсын комиссын актаар хүлээж авсан 14 төсөл, арга хэмжээг дараах ашиглагч байгууллагууд бүртгэл, тайланд бүрэн тусгасан байна. Үүнд:

- Аймгийн Боловсролын газар нь хуваарийн дагуу 33 сургуульд олгосон зөөврийн компьютерыг үндсэн хөрөнгөд, 17 цэцэрлэгт олгосон Steam сургалтын хэрэглэгдэхүүнийг бараа материалын дансанд,
- Аймгийн болон Мандал сумын нэгдсэн эмнэлгүүд нь эмнэлгийн тоног төхөөрөмжийг, Жавхлант сумын сургууль, Мандал сумын 1, 2 дугаар сургууль, Түнхэл тосгоны сургууль нь цахим ангийн сургалтын тоног төхөөрөмжийг,
- Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс нь албан өрөөний тавилга, компьютер, техник хэрэгсэл болон фитнесийн тоног төхөөрөмжийг,
- Алтанбулаг сумын ЗДТГ нь газар доогуурх инженерийн шугам сүлжээ, Сайхан сумын ЗДТГ нь Залуучуудын хөгжлийн төвийн барилга, Мандал сумын ЗДТГ нь ахмадын төвийн барилга, Жавхлант сумын ЭМТ нь барилгын өргөтгөлийг тус тус үндсэн хөрөнгөд,
- Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газар нь дээврийн их засварыг, Мандал сумын 1 дүгээр сургууль, Хэрх тосгоны Захирагчийн алба нь халаалтын зуухны шинэчлэлт, засварын ажлыг тус тус капиталжуулж,
- Түшиг сумын цэцэрлэг нь гадна талбайг бусад үндсэн хөрөнгөд гэх мэт.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **15,372.0** сая төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Албан шаардлага:

- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй нийт 14,154.0 сая төгрөг (төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, баталгаажуулаагүй 8,022.5 сая төгрөг, зураг, төсөвт магадлал хийлгэж, баталгаажуулаагүй 2,953.9 сая төгрөг, техникийн тодорхойлолт, зураг төсөв нь урьдчилан хийгдээгүй 3,177.6 сая төгрөг зэрэг) -ийн 17 төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн,

²³ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, ...

²⁴ Эцсийн буюу бүрэн санхүүжилтийг авахад тухайн төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж, баримт бичгийн иж бүрдэлд хавсаргах бөгөөд цахим системд баталгаажуулсан байна.

- 7 төсөл, арга хэмжээний 115.6 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг банкны болон даатгалын байгууллагаар баталгаажуулаагүй бөгөөд гүйцэтгэлийн баталгааг 67.4 сая төгрөгөөр дутуу гаргасан 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулсан,
- Улсын комиссын актаар хүлээж авсан 2 төсөл, арга хэмжээний чанарын баталгааны 35.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулаагүй.
- 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий *“Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилга худалдан авах /Сэлэнгэ, Сүхбаатар сум/”* төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтод эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг тусгаагүйгээс сонгон шалгаруулалтын дараа шаардлагад нийцүүлэн засварлахаар гэрээ байгуулсан, засварын үйл ажиллагаанд гэрээний дагуу хяналт шалгалт хийгдээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- “Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-тэй уялдуулаагүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй болон төсөвлөлтийн шаардлага хангаагүй, Төрийн хэмнэлийн тухай хууль зөрчсөн төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөж, эрх шилжүүлсэн байна.
- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг УТХО-ын төлөвлөгөөнд тусгаж, батлах, эрх шилжүүлэх тушаал, шийдвэрийг тогтоосон хугацаанд гаргаагүй зэрэг нь төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад орохгүй байх эрсдэлийг үүсгэж байна.
- Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг банк, даатгалын байгууллагаар баталгаажуулаагүй, хувь хэмжээг зөрүүтэй тооцсон, чанарын баталгааг байршуулаагүй зэргээр холбогдох хууль эрхийн актыг зөрчсөн байна.
- Төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, улсын комиссын актаар хүлээн авч, ашиглагч байгууллагууд нь бүртгэл, тайланд бүрэн тусгасан боловч зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хувийг бодитоор үнэлэлгүйгээр санхүүжилтийг олгосон байна.
- Аймгийн Засаг дарга бус Сүхбаатар сумын Засаг даргын баталсан *“Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилга худалдан авах (Сэлэнгэ, Сүхбаатар сум)”* төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл шаардлага */дотоод засал, хийц, материал, ослын үеийн болон тусгай хэрэгцээт иргэнд зориулсан орц, гарц, шат гэх мэт /-ыг тусгалгүйгээр гүйцэтгэгчийг шалгаруулсан бөгөөд тус барилгын засварын явц, гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.*

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д:

- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож, эрэмбэлсэн, төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг УТХО-аар хэрэгжүүлэх санал хүргүүлэх зэргээр холбогдох хууль эрх зүйн актыг хэрэгжүүлэн ажиллах.
- Төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод нөхцөл, шаардлагыг иж бүрэн тусгах, худалдан авах ажиллагааны “Үнэлгээний хороо”-г аймгийн Засаг даргын захирамжаар байгуулах замаар худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрх зүйн актад нийцүүлэх.
- МУ-ын тухайн жилийн Төсвийн тухай хуулиар төлөвлөж, баталсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулах, үр нөлөө бүхий захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсний үндсэн дээр төлөвлөсөн төсвийн жилд нь багтаан ашиглалтад оруулах.

Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Октябрь-т:

- Сумын Засаг даргын бус захиалагч болох аймгийн Засаг даргын баталсан техникийн тодорхойлолтыг үндэслэн тендерийн бичиг баримтыг боловсруулах, “Үнэлгээний хороо”-ны үйл ажиллагаанд хяналт тавих зэргээр худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн хүрээнд зохион байгуулах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

С.БААСАНСҮРЭН

Ж.ЦОГТ

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 1 байр, Их суварга 505.

Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081

Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn


Цахим хуудас: www.selenge.gov.mn

2025.04.18 № 011483

танай _____-ны № _____

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа, тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно.


Н.ЛХАГВАДОРЖ

432500659

C:\user\албан бичиг 2025\Засаг дарга жижиг тоот А5